



СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС











ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

Статистикийн танилцуулга

2017/8



АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2015-2017 ОН	4
 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	5
 ДҮҮРГИЙН ТӨСӨВ	8
 АЖ ҮЙЛДВЭР	11
 ГАЗАР ТАРИАЛАН	13
 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	13
 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	14
 ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ	16
 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	17
 ГЭМТ ХЭРЭГ	19
ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ	20

ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Жил бүрийн эхний 8 сарын байдлаар


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2015 он	2016 он	2017 он
Суурин хүн ам, сарын эцэст	хүн	140955	153515	161905
Шинээр төрсөн хүүхэд	тоо	2984	3017	2895
Бүртгэлтэй ажилгүй иргэд, сарын эцэст	хүн	1449	1301	616
Үүнээс: эмэгтэй	хүн	760	681	328
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	тоо	2603	2744	1754
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	942	1108	1109
Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индексийн сарын өөрчлөлт	хувь	0.1	-0.6	1.3
Валютын зах зээлийн ханш, сарын эцэст	1US\$ =₮	1991.5	2220.0	2430.0
Дүүргийн төсвийн орлого	сая.төг	30726.1	33800.7	35822.5
Дүүргийн төсвийн зарлага	сая.төг	26757.3	28259.5	29687.4



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2017 оны 8-р сарын хэрэглээний үнийн индекс 2016 оны мөн үетэй харьцуулахад 5.4 хувиар, 2016 оны эцэстэй харьцуулахад 6.0 хувиар тус тус өсч, харин өмнөх сартай харьцуулахад 1.3 хувиар буурсан байна.

Зураг 1. Хэрэглээний үнийн индекс, 2015-2017 он



Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс 2017 оны 8-р сард өмнөх оны эцэстэй харьцуулахад 6.0 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 11.8 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 2.1 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 1.2 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 1.7 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 4.2 хувь, тээврийн үйлчилгээ 9.2 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ 0.5 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ 2.3 хувь, боловсролын үйлчилгээ 7.5 хувь, бусад бараа, үйлчилгээ 4.3 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Хүснэгт 1. Хэрэглээний үнийн индекс, барааны бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	<u>2016-08</u> 2015-08	<u>2017-08</u> 2016-08	<u>2017-08</u> 2016-12	<u>2017-08</u> 2017-07
Ерөнхий индекс	99.4	105.4	106.0	101.3
Хүнсний бараа, ундаа, ус	96.8	106.9	111.8	100.6
Согтууруулах ундаа, тамхи	103.0	102.5	102.1	100.0
Хувцас, бөс бараа, гутал	99.4	102.0	101.2	100.3
Орон сууц, ус, цахилгаан, түлш	98.7	108.4	104.4	105.7
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	101.6	101.3	101.7	100.2
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	109.0	105.1	104.2	101.1
Тээвэр	98.3	109.6	109.2	100.3
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.7	100.5	100.5	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	99.2	100.1	102.3	100.1
Боловсролын үйлчилгээ	102.6	107.5	107.5	107.5
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	101.4	100.2	99.7	100.1
Бусад бараа, үйлчилгээ	100.3	105.7	104.3	100.3

2017 оны 8-р сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 344 нэрийн бараа, үйлчилгээний 15.7 хувийнх нь үнэ өсч, 24.7 хувийнх нь үнэ буурч, 59.6 хувийн бараа үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад тогтвортой байлаа.

Хүснэгт 2. Улаанбаатар хотын хэрэглээний үнийн сарын индекст нөлөөлсөн бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлт

Бараа, үйлчилгээний бүлэг	Үнийн өөрчлөлт %	Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт
Хүнсний бараа, ундаа, ус	0.6	Энэ бүлгийн өсөлтөд талх, гурил, будаа 0.6 хувиар, төрөл бүрийн өөх, тос 1.7 хувиар, хүнсний ногоо 20 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.
Хувцас, бөс бараа, гутал	0.3	Энэ бүлгийн өсөлтөд хөвөн, бөс бараа 1.1 хувиар, бүх төрлийн хувцас 0.5 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.
Орон сууц, ус, цахилгаан, түлш	5.7	Энэ бүлгийн өсөлтөд сууц хөлслөгчийн бодит түрээс 10.1 хувиар, орон сууцны урсгал засварын бараа, материал 1.7 хувиар, хатуу түлш 6.2 хувиар өссөн нь нөлөөлжээ.
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	0.2	Гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн өсөлтөд гэр ахуйн удаан эдэлгээт цахилгаан болон бусад бараа 0.4 хувиар, гэр ахуйн жижиг багаж хэрэгсэл 0.4 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	1.1	Эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн өсөлт нь эм, тариа 1.5 хувиар, амбулаторын үйлчилгээ 7.6 хувиар өссөнтэй холбоотой байв.
Тээвэр	0.3	Тээврийн үйлчилгээний бүлгийн өсөлт нь тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ 2.7 хувиар, агаарын зорчигч тээврийн үйлчилгээ 4.7 хувиар өссөнөөс шалтгаалсан байна.
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	0.3	Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн өсөлтөд бичгийн болон зургийн хэрэгсэл 1.2 хувиар өссөн нь нөлөөлжээ.
Боловсролын үйлчилгээ	7.5	Энэ бүлгийн өсөлт нь бага боловсрол 8.8 хувиар, бүрэн дунд боловсрол 32.1 хувиар, боловсрол олгох бусад үйлчилгээ 4.2 хувиар тус тус өссөнтэй холбоотой байна.
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	1.1	Энэ бүлгийн өсөлтөд зочид буудал, дотуур байрны үйлчилгээ 5.0 хувиар өссөн нь нөлөөлжээ.
Бусад бараа, үйлчилгээ	0.3	Бусад бараа, үйлчилгээний өсөлт нь гоо сайхны хэрэгцээнд зориулсан бусад эд зүйлс 0.5 хувиар өссөнөөс шалтгаалжээ.

Эх үүсвэр: "Нийслэлийн нийгэм, эдийн засгийн байдал" статистикийн 2017 оны 8-р сарын танилцуулга

2017 оны 8-р сарын 28-ны өдрийн үнийн ажиглалтаар Хан-Уул дүүргийн хүнсний зах, дэлгүүрүүдээр худалдаалагдаж байгаа хүнсний өргөн хэрэглээний 16 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад “Алтан тариа” ХК-ийн дээд зэргийн гурил 50 төгрөг, элсэн чихэр 400 төгрөг, төмс 50 төгрөг, байцаа 400 төгрөг, лууван 200 төгрөг, цагаан будаа 100 төгрөг, задгай сүү 400 төгрөг, “Сүү” ХК-ны цөцгийтэй тараг 630 төгрөгөөр тус тус өсч, үхрийн мах 700 төгрөг, “Алтан тариа” ХК-ийн 1-р зэргийн гурил 50 төгрөг, манжин 300 төгрөг, сонгино 100 төгрөгөөр тус тус буурсан байна. Харин “Алтан тариа” ХК-ийн 2-р зэргийн гурил, хонины мах, фүжи алим, “Талх чихэр” ХК-ны “Атар” талхны үнэ тогтвортой байлаа.

Хүснэгт 3. Хүнсний өргөн хэрэглээний барааны дундаж үнэ*, жил бүрийн 8-р сарын байдлаар


Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2016.08	2017.08	$\frac{2017}{2016}$ %
Талх “Атар”, “Талх чихэр” ХК	Ширхэг	1160	1160	100.0
Хонины мах, ястай	Кг	5000	5000	100.0
Үхрийн мах, ястай	Кг	7200	6500	90.3
Гурил , дээд зэрэг, “Алтан тариа”	Кг	1400	1450	103.6
Гурил ,1-р зэрэг, “Алтан тариа”	Кг	1170	1120	95.7
Гурил, 2-р зэрэг, “Алтан тариа”	Кг	900	900	100.0
Элсэн чихэр	Кг	1900	2300	121.1
Төмс, монгол	Кг	800	850	106.3
Байцаа, монгол	Кг	1500	1900	126.7
Лууван, монгол	Кг	1800	2000	111.1
Манжин, монгол	Кг	1800	1500	83.3
Сонгино, хятад	Кг	1600	1500	93.8
Цагаан будаа	Кг	2300	2400	104.3
Алим, фүжи	Кг	4500	4500	100.0
Сүү, задгай	литр	1100	1500	136.4
Тараг, цөцгийтэй, “Сүү ” ХК	литр	1900	2530	133.2

*- Худалдаа үйлчилгээний “Мөнхсүврага” төв


Зураг 2. Нэг кг махны дундаж үнэ, төгрөг




Зураг 3. Нэг кг гурилын дундаж үнэ, төгрөг



Зураг 4. Нэг кг төмс, лууван, байцааны дундаж үнэ, төгрөг



Зураг 5. Нэг кг манжин, сонгины дундаж үнэ, төгрөг



Хүснэгт 4. Нэг литр шатахууны үнэ, 2017.08.28-ний байдлаар, төгрөг

ШТС	2016.08.31					2017.08.31				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Жаст Ойл	1730		1530	1640		1820				
Петровис	1730	1450	1530	1640		1820	1480	1630	1720	
Магнай трейд	1730	1450	1500	1640		1820	1480	1630	1720	
Сод монгол	1700		1530	1640		1820				
Шунхлай	1730	1450	1530	1600	850			1630	1720	
Юнигаз					900					1050
Дундаж үнэ	1723	1450	1518	1624	900	1820	1480	1630	1720	1050


Эх үүсвэр: "Нийслэлийн нийгэм, эдийн засгийн байдал" статистикийн 2017 оны 8-р сарын танилцуулга



ДҮҮРГИЙН ТӨСӨВ

2017 оны эхний 8 сард дүүргийн орон нутгийн төсвийн орлого 35.8 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 225.5 сая төгрөгөөр буюу 0.6 хувиар тасарсан байна.

Зураг 6. Төсвийн орлого, зарлага, 2011-2017 он, сая төг



Төсвийн нийт орлогын 32.6 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 6.1 хувийг татварын бус орлого (нийтлэг татварын бус орлого), 61.3 хувийг улсын төсөв болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг эзэлж байна.

Хүснэгт 5. Дүүргийн төсвийн орлого, 2017 оны эхний 8 сард сая.төг


Төсвийн орлого			Үүнээс:									
Бүгд	ТБ %	Зөрүү сая. төг	Татварын орлого			Татварын бус орлого			Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгийн орлого			
			Бүгд	ТБ %	Зөрүү сая.төг	Бүгд	ТБ %	Зөрүү сая.төг	Бүгд	ТБ %	Зөрүү сая.төг	
Дүн	35822.5	99.4	-225.8	11680.8	95.3	-572.4	2179.9	122.7	404.0	21961.8	99.7	-57.3

Татварын орлогын хэмжээ 11.7 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 572.4 сая төгрөгөөр буюу 4.7 хувиар тасарсан байна. Харин татварын бус орлого 2.2 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 404.0 сая төгрөгөөр буюу 22.7 хувиар давж биелэсэн байна.

Бусад татвар, төлбөр, хураамж төлөвлөснөөс 1.6 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн албан татвар төлөвлөснөөс 0.7 сая төгрөгөөр тус тус тасарсан бол орлогын албан татвар төлөвлөснөөс 1.0 сая төгрөгөөр илүү бүрджээ.

Татварын бус орлогын 76.0 хувийг торгуулийн орлого, 24.0 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого болон бусад орлого болон бусад орлого эзэлж байна.

Зураг 7. Татварын орлогын бүтэц, хувиар



Зураг 8. Татварын бус орлогын бүтэц, хувиар



2017 оны эхний 8 сард орон нутгийн төсвөөс төсөвт байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 89.0 хувийг буюу 29.7 тэрбум төгрөгийн зардлыг санхүүжүүлжээ. Өөрөөр хэлбэл, төсөвт байгууллагууд үйл ажиллагааны нийт зардлын 11.0 хувийг буюу 3.7 тэрбум төгрөгийг төлөвлөсөн хугацаандаа зарцуулаагүй байна.

Хүснэгт 6. Дүүргийн төсвийн орлого, 2017 оны эхний 8 сард сая.төг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ, %	Зөрүү
Орон нутгийн орлого	36048.4	35822.5	99.4	-225.8
1.Татварын орлогын дүн	12253.2	11680.8	95.3	-572.4
1.1 Орлогын албан татвар	5945.3	6950.5	116.9	1005.2
Хувь хүний орлогын албан татвар	5945.3	6950.5	116.9	1005.2
1.2 Хөрөнгийн албан татвар	23.7	23.0	97.0	-0.7
1.3 Бусад татвар,төлбөр, хураамж	6284.2	4707.3	47.9	-1576.9
Улсын тэмдэгтийн хураамж	5225.7	3350.5	64.1	-1875.2
Ашигт малтмал ашигласны төлбөр	58.5	35.5	60.7	-23.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1000.0	1321.3	132.1	321.3
2.Татварын бус орлогын дүн	1776.0	2179.9	122.7	404.0
Төсөвт байгууллагын өөрийн орлого	699.8	469.4	67.1	-230.4
Торгуулийн орлого	1023.2	1657.0	161.9	633.8
Бусад орлого	53.0	53.5	100.9	0.5
3. Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	22019.2	21961.8	99.7	-57.3
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	21849.0	21843.3	100.0	-5.7
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	170.2	118.5	69.6	-51.7

Төсвийн нийт зарлагын 46.7 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 5.1 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 5.5 хувийг татаас болон урсгал шилжүүлэг, 42.7 хувийг бараа, ажил үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Хүснэгт 7. Дүүргийн төсвийн орлого, зарлага, 2017 оны эхний 8 сард сая.төг

	Орлого	Зарлага				Орлого, зарлагын зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү	
Нийт дүн	35822.5	33361.3	29687.4	89.0	-3673.9	6135.1

Дүүргийн төсвөөс болон тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагууд тухайн сарын эхэнд 83.4 сая төгрөгийн өглөгтэй байсан бөгөөд 80.9 сая төгрөгийн өглөг шинээр үүсч, 37.0 сая төгрөгийн өглөгийг барагдуулж, сарын эцэст нийт 127.3 сая төгрөгийн өглөгтэй болсон байна.

Хүснэгт 8. Өглөг, 2017 оны эхний 8 сард, сая.төг


	8-р сарын эхний үлдэгдэл	Шинээр үүссэн өглөг	Тухайн сард төлөгдсөн	8-р сарын эцсийн үлдэгдэл
Нийт дүн	83.4	80.9	37.0	127.3



АЖ ҮЙЛДВЭР

Дүүргийн аж үйлдвэрийн газрууд 2017 оны эхний 8 сард 572.0 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 526.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 8.4 хувиар, борлуулалт 17.6 хувиар тус тус өссөн байна.

Зураг 9. Аж үйлдвэрийн үйлдвэрлэлт, борлуулалт, 2016-2017 оны сар бүрээр, тэрбум төгрөг



Хүснэгт 9. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, салбараар, өссөн дүнгээр

/оны үнээр, сая төгрөг/

Салбараар	Нийт бүтээгдэхүүн		
	2016 он I-VIII сар	2017 он I-VIII сар	$\frac{2017}{2016}$ %
Уул уурхай олборлох үйлдвэр	8720.3	10700.6	122.7
Төмрийн хүдэр олборлолт	8238.6	10001.9	121.4
Бусад ашигт малтмал олборлолт	481.7	698.7	145.0
Боловсруулах үйлдвэр	452062.8	492266.7	108.9
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	236347.1	217570.9	92.1
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	3004.6	1285.4	42.8
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1494.1	10535.9	7.0*
Хүнсний бусад бүтээгдэхүүн	16681.9	21993.0	131.8
Ундаа үйлдвэрлэл	215166.5	183756.6	85.4
Нэхмэлийн үйлдвэрлэлт	164827.7	197061.1	119.6
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	1437.8	2077.9	144.5
Арьс шир боловсруулах үйлдвэр	5200.2	9249.4	177.9
Мод, модон эдлэл	1981.9	4228.2	213.3
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	3225.8	6143.3	190.4
Хэвлэл болон дуу бичлэгийн үйл ажиллагаа	4245.9	4708.7	110.9
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	25540.6	41442.2	162.3
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн	5682.2	5154.6	90.7
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	2504.9	3163.3	126.3
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл	71.5	148.7	208.0
Бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл	13.8	220.6	15.0*
Эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэл	792.7	847.0	106.9
Мебель тавилга үйлдвэрлэл	190.7	250.8	131.5
Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэлт	67061.5	69034.8	102.9
ДҮН	527844.6	572002.1	108.4


*-дахин

Хүснэгт 10. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний борлуулалт, салбараар, өссөн дүнгээр /оны үнээр, сая төгрөг/


Салбараар	Аж үйлдвэрийн борлуулалт			
	2016 он I-VIII сар	2017 он I-VIII сар	$\frac{2017}{2016}$ %	үүнээс: экспорт, %
Уул уурхай олборлох үйлдвэр	6465.7	8367.0	129.4	0.1
Төмрийн хүдэр олборлолт	5984.0	7668.3	128.1	-
Бусад ашигт малтмал олборлолт	481.7	698.7	145.0	100.0
Боловсруулах үйлдвэр	374081.0	448973.1	145.0	21.8
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	191840.7	220640.8	115.0	0.6
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	4394.9	1285.4	29.2	45.2
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1783.3	11445.7	641.8	
Хүнсний бусад бүтээгдэхүүн	16144.9	21336.5	132.2	
Ундаа үйлдвэрлэл	169517.6	186573.2	110.1	0.4
Нэхмэлийн үйлдвэрлэлт	128202.9	148136.9	115.5	59.7
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	1321.8	2057.6	155.7	
Арьс шир боловсруулах үйлдвэр	5246.4	9264.6	176.6	87.2
Мод, модон эдлэл	1981.9	4228.2	213.3	
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	3222.4	6143.3	190.6	
Хэвлэл болон дуу бичлэгийн үйл ажиллагаа	5656.8	5029.2	88.9	
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	27370.9	43101.3	157.5	
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн	5682.2	5300.2	93.3	
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	2513.2	3367.4	134.0	
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл	70.1	148.7	212.1	
Бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл	54.2	220.6	407.0	
Эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэл	726.8	1083.5	149.1	
Мебель тавилга үйлдвэрлэл	190.7	250.8	131.5	
Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэлт	67061.5	69034.8	102.9	
ДҮН	447608.2	526374.9	117.6	18.7

*-дахин

Зураг 10. Үйлдвэрлэлт, 2015-2017 он, тэрбум төг



Зураг 11. Борлуулалт, 2015-2017 он, тэрбум төг



Аж үйлдвэрийн нийт борлуулалтын 427.8 тэрбум төгрөгийг дотоодод, 98.5 тэрбум төгрөгийг гадаадад борлуулсан байна. Нийт борлуулсан бүтээгдэхүүний 18.7 хувийг экспортод гаргасан бөгөөд нийт экспортын 89.7 хувийг ноос, ноолуур, нэхмэлийн үйлдвэрлэлт, 9.8 хувийг арьс ширний үйлдвэрлэлт, 0.9 хувийг ундаа үйлдвэрлэлт, 0.7 хувийг мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, 0.7 хувийг бусад ашигт малтмал олборлолт тус тус эзэлж байна.



ГАЗАР ТАРИАЛАН


2017 оны 8-р сард ургац хураалтын явцын мэдээгээр 14.0 тонн төмс, 52.0 тонн хүнсний ногоо хураан авсан байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал төмс 0.8 тонн буюу 6.1 хувиар, хүнсний ногоо 0.2 тонн буюу 0.4 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 11. Ургац хураалт, 8-р сарын байдлаар, тн

Үзүүлэлт	2016.08	2017.08	Өсөлт бууралт /хувиар/
Төмс	13.2	14.0	6.1
Хүнсний ногоо	52.8	53.0	0.4
Байцаа	15.0	16.0	6.6
Лууван	5.2	4.2	-19.2
Шар манжин	2.1	2.0	-4.8
Улаан манжин	1.8	4.8	1.6*
Сонгино	4.0	2.6	-35
Өргөст хэмх	15.1	3.5	-76.8
Улаан лооль	5.0	18.3	2.6*
Чинжүү	1.6	-	-
Бусад	2.2	3.0	36.4

*-дахин

Зураг 12. Ургац хураалт, жил бүрийн 8-р сарын байдлаар, тн



НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2017 оны эхний 8 сарын байдлаар нийгмийн халамжийн сангийн нийт орлогын 14.5 хувийг жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмжинд, 3.5 хувийг алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжинд тус тус хуваарилсан байна.

Харин зарлагын 59.0 хувийг нийгмийн халамжийн санд буюу нийт 14768 хүнд, 7521 хүнд алдарт эхийн одонгийн тусламж, 273 хүнд алдар цолтой ахмадын хөнгөлөлт, тусламж, 6813 хүнд жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмжийг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 12. Нийгмийн халамжийн сангийн үзүүлэлт, оны эхний 8 сард, сая.төг

Үзүүлэлт	Дүн	Хүний тоо
Нийгмийн халамжийн сангийн орлого	9581.6	
1.Нийслэлийн төсвийн санхүүжилтийн орлого	7195.0	
а) Нийгмийн халамжийн сан	5544.3	
б) жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж	1389.3	
в) ОНОТХаламжийн үйлчилгээ	86.8	
г) хүнс тэжээл хөтөлбөр	174.6	
2. Улсын төсвийн санхүүжилтийн орлого	2377.4	
а) алдарт эхийн одонгийн тусламж	975.0	
б) алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	340.0	
В) насны хишиг	1062.4	
3. Үйлчилгээний орлого	9.2	
а) хүүгийн орлого	7.0	
б) маягтын орлого		
в) бусад орлого	2.2	
Зарлагын нийт дүн	9596.6	36305
1. Нийгмийн халамжийн сан	5667.1	14768
2. Жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж	1378.2	6813
3. Алдарт эхийн одонгийн тусламж	978.8	7521
4. Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	333.7	273
5. Хүнс тэжээл хөтөлбөр	177.1	393
6. ОНОТХ Үйлчилгээний зардал	10.1	52
7. Насны хишиг	1051.6	6485



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

2017 оны эхний 8 сард Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 2986 байгууллагын нийт 121.7 мянга гаруй хүн хамрагдаж, шимтгэл төлсөн ба тэдгээрийн 58.3 мянга буюу 47.9 хувь нь ААНБ-ын, 10.1 мянга буюу 8.3 хувь нь төсвийн байгууллагын, 8.8 мянга буюу 7.3 хувь нь сайн дурын даатгуулагчид, 44.4 мянга буюу 36.5 хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагчид байна.

Хүснэгт 13.Нийгмийн даатгалын байгууллагаар үйлчлүүлсэн байгууллага болон даатгуулагчийн тоо

Үзүүлэлт	2016.08	2017.08	Өсөлт	
			тоо	хувь
Нийт байгууллагын тоо	2806	2952	180	106.4
Аж ахуйн нэгж байгууллагын тоо	2691	2866	175	106.5
Төсөвт байгууллагын тоо	115	120	5	104.3
Нийт даатгуулагчдын тоо	104938	121670	16732	115.9
ААНБ-ын даатгуулагчийн тоо	51220	58261	7041	113.7
Төсөвт байгууллагын даатгуулагчийн тоо	9614	10145	531	105.5
Сайн дурын даатгуулагчийн тоо	7924	8844	920	111.6
Эрүүл мэндийн даатгуулагчийн тоо	36180	44420	8240	122.8

2017 оны эхний 8 сард дүүргийн нийгмийн даатгалын сангийн нийт орлого 86.6 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 16.6 тэрбум төгрөгөөр илүү бүрдсэн буюу 23.7 хувиар давж биелсэн байна. Орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.2 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.


Хүснэгт 14. Нийгмийн даатгалын сангийн орлого, сан тус бүрээр, оны эхний 8 сард

Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Биелэлт %	
	2016.08	2017.08	2016.08	2017.08	2016	2017
Тэтгэврийн даатгалын сангийн орлого	41328.4	44449.1	44927.4	54586	108.7	122.8
Тэтгэмжийн сангийн орлого	4726.9	5509.8	5092.9	6994.9	107.7	127.0
ҮОМШӨ*-ний даатгалын орлого	4730.6	4589.8	5955.7	6506.7	125.9	141.8
Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого	1097.9	1217.3	1199.2	1426.8	109.2	117.2
Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого	13173.1	14212.4	13394.7	17049.9	101.7	120.0
Нийт	65056.8	69978.4	70569.9	86564.3	108.5	123.7


Тайлбар: ҮОМШӨ-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин

Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 63.1 хувийг тэтгэврийн даатгалын санд, 8.1 хувийг тэтгэмжийн даатгалын санд, 7.5 хувийг ҮОМШӨ-ний даатгалын санд, 1.6 хувийг ажилгүйдлийн даатгалын санд, 19.7 хувийг эрүүл мэндийн даатгалын сангийн орлого тус тус эзэлж байна.

Зураг13. Нийгмийн даатгалын сангийн орлогын бүтэц, хувиар



Зураг 14. Нийгмийн даатгалын сангийн зарлагын бүтэц, хувиар



Тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч 13193 хүнд 37.7 тэрбум төгрөгийг, тахир дутуугийн тэтгэвэр авагч 2913 хүнд 5.5 тэрбум төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 786 хүнд 1.5 тэрбум төгрөгийг, цэргийн тэтгэвэр авагч 1029 хүнд 4.4 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсан 7636 хүнд 1066.4 сая төгрөгийг, жирэмсэн болон амаржсан 2765 хүнд 3.9 тэрбум төгрөгийг, 35 хүнд оршуулгын тэтгэмж 35.1 сая төгрөгийг тус тус олгожээ.


ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагч 167 хүнд 589.7 сая төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 18 хүнд 44.9 сая төгрөгийг, тэтгэмж төлбөрт 76 хүнд 51.1 сая төгрөгийг, ҮОМШӨ-ний сувилалд 24 хүнд 3.0 сая төгрөгийн тус тус олгосон байна. Ажилгүйдлийн тэтгэмж авсан 1291 хүнд 2.5 тэрбум төгрөг зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангийн нийт зардлын 63.3 хувийг тэтгэврийн, 7.9 хувийг тэтгэмжийн, 7.6 хувийг ҮОМШӨ-ний, 2.9 хувийг ажилгүйдлийн 18.3 хувийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

Зураг 15. Даатгалын сангийн орлого, зарлага сая.төг



Зураг 16. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо



ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2017 оны 8-р сарын байдлаар 616 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 685 хүнээр буурсан байна. Нийт ажилгүйчүүдийн 53.4 хувь нь эмэгтэйчүүд байна.


Энэ оны 8-р сард орон тооны цомхтголоор 31, байгууллага татан буугдсанаас 11, өөр газраас шилжиж ирсэн 16, сургууль төгссөн 12, цэргээс халагдсан 2, мэргэжлийн ажил олдохгүй 6, цалин багатайгаас 15, бусад шалтгаанаар 105 хүн ажилгүй болжээ.

Тайлант сард 14 хүн ажилд орсноос төрийн төсөвт байгууллагад 2, нөхөрлөл компанид 11, бусад байгууллагад 1 хүн ажилд орсон байна.

Хүснэгт 15. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр, жил бүрийн 8-р сарын эцэст

Үзүүлэлт	Ажилгүйчүүдийн тоо			Дүнд эзлэх хувь		
	2015.VIII	2016.VIII	2017.VIII	2015.VIII	2016.VIII	2017.VIII
Нийт ажилгүйчүүд	1449	1301	616	100.0	100.0	100.0
Дээд боловсролтой	691	744	283	47.7	57.2	46.0
Тусгай дунд боловсролтой	72	74	27	5.0	5.7	4.4
Мэргэжлийн анхан шатны	72	54	18	5.0	4.1	2.9
Бүрэн дунд боловсролтой	556	409	273	38.3	31.4	44.3
Бүрэн бус дунд боловсролтой	42	14	10	2.9	1.1	1.6
Бага, боловсролгүй	16	6	5	1.1	0.5	0.8

Зураг 17. Ажилгүйчүүд насны бүлгээр, 8-р сарын эцэст



Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 40.0 хувь буюу 246 нь анх удаа ажил хайж байгаа бол 60.0 хувь буюу 370 нь урьд ямар нэг ажил хийж байжээ. Насны бүлгээр авч үзвэл нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 11.5 хувь буюу 71 нь 16-24 насны, 41.6 хувь буюу 256 нь 25-34 насны, 28.2 хувь буюу 174 нь 35-44 насны, 18.7 хувь буюу 115 нь 45-60 насны хүмүүс байна.




ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ


Дүүргийн хэмжээнд 2017 оны эхний 8 сард нийт 1754 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 36.1 хувиар буюу 990 хүнээр, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 76.7 продицимилээр тус тус буурсан байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 28.3 хувийг салхин цэцэг, 9.2 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 4.5 хувийг тэмбүү, 20.4 хувийг гар хөл амны өвчин, 3.5 хувийг трихомониаз, 12.0 хувийг цусан суулга, 1.5 хувийг заг хүйтэн, 1.0 хувийг вируст гепатит, 0.7 хувийг гахайн хавдар, 18.9 хувийг бусад өвчнөөр өвчлөгчид тус тус эзэлж байна.

Зураг 18. Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд



Зураг 19. Халдварт өвчнөөр өвчлөгчид



Хүснэгт 17. Эх, хүүхдийн эндэгдэл, жилийн бүрийн 7 сард

Үзүүлэлт	2015 он	2016 он	2017 он	$\frac{2017}{2016}$ %
Амаржсан эхийн тоо	2968	3004	2875	-4.3
Амьд төрсөн хүүхэд	2984	3017	2895	-4.0
Төрөхийн улмаас эндсэн эх	1	2	1	-50
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	32	28	32	14.2
1-5 хүртэл насандаа эндсэн хүүхэд	5	8	5	-37.5

2017 оны 8 сард төрөхийн улмаас эндсэн эхийн тоо өмнөх оны мөн үеэс 1 эхээр, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 3 хүүхдээр тус тус буурч, нялхсын эндэгдэл өмнөх оны мөн үеэс 4-өөр нэмэгджээ.

Хүснэгт 16. Дүүрэгт гарсан халдварт өвчин, жил бүрийн 8 сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 он	2017 он	өсөлт, бууралт	
				тоо/пункт	Хувь
НИЙТ ХАЛДВАРТ ӨВЧИН	Бодит тоо 10000 хүнд	2744 189.7	1754 113.0	-990 -76.7	-37.6
Вируст гепатит	Бодит тоо 10000 хүнд	18 1.2	18 1.2	- -	-
Цусан суулга	Бодит тоо 10000 хүнд	150 10.4	211 13.6	61 3.2	40.6
Улаан эсэргэнэ	Бодит тоо 10000 хүнд	67 4.6	148 9.5	81 4.9	1.2 дах
Сальмонеллэз	Бодит тоо 10000 хүнд	9 0.6	11 0.7	2 0.1	22.2
Салхин цэцэг	Бодит тоо 10000 хүнд	288 19.9	496 32	208 12.1	72.2
Гахайн хавдар	Бодит тоо 10000 хүнд	15 1	13 0.8	-2 -0.2	-13.3
Ёлом	Бодит тоо 10000 хүнд	9 0.6	8 0.5	-1 -0.1	-11.1
Гар хөл, амны өвчин	Бодит тоо 10000 хүнд	394 27.2	358 23.1	-36 -4.1	-9.13
Тэмбүү	Бодит тоо 10000 хүнд	80 5.5	79 5.1	-1 -0.5	-1.25
Заг хүйтэн	Бодит тоо 10000 хүнд	26 1.7	27 1.8	-1 0.1	3.84
Трихомониаз	Бодит тоо 10000 хүнд	72 5	62 4	-10 -1	-13.8
Шинээр илэрсэн сүрьеэ	Бодит тоо 10000 хүнд	204 14.1	162 10.4	-42 -3.7	-20.5
Мөөгөнцөр	Бодит тоо 10000 хүнд	5 0.3	3 0.2	-2 -0.1	-40
Улаан бурхан	Бодит тоо 10000 хүнд	1366 94.4	1 0.06	-1365 -94.34	-99.9
Бусад өвчлөл	Бодит тоо 10000 хүнд	41 3	157 10.1	116 7.1	2.9 дах



ГЭМТ ХЭРЭГ

Дүүргийн хэмжээнд 2017 оны эхний 8 сард 1109 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 0.1 хувиар буюу 1 хэргээр өсчээ.

Зураг 20. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо




Нийт гэмт хэргийн 31.5 хувь буюу 349 нь хулгайн хэрэг, 28.4 хувь буюу 265 нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг хэрэг, 8.6 хувь буюу 95 хэрэг нь залилан мэхлэх гэмт хэрэг, 4.2 хувь буюу 47 хэрэг нь олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах хэрэг, 2.6 хувь буюу 29 нь хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх хэрэг, 0.9 хувь буюу 10 нь хүчингийн хэрэг, 1.5 хувь буюу 17 нь дээрэмдэх хэрэг, 6.7 хувь буюу 74 нь ХАБТХАЖЭ хэрэг, 0.4 хувь буюу 4 нь хүнийг алах хэрэг, 0.5 хувь буюу 6 нь малын хулгайн хэрэг, 14.7 хувь буюу 163 нь бусад гэмт хэргүүд тус тус эзэлж байна.

Хүснэгт 17. Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр

Гэмт хэргийн төрөл	Гэмт хэргийн тоо		Өсөлт, бууралт	
	2016.8	2017.8	$\frac{2017}{2016}$ %	Тоо
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	15	29	93.3	14
Хүчин	9	10	11.1	1
Дээрэм	20	17	-15.0	-3
Хулгай	290	349	20.3	59
Залилан мэхлэх	130	95	-26.9	-35
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	366	315	-13.9	-51
Малын хулгай	8	6	-25.0	-2
Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	61	47	-23.0	-14
Хүнийг санаатай алах	3	4	33.3	1
ХАБТХАЖЭ	61	74	21.3	13
Бусад	145	163	12.4	18
БҮГД	1108	1109	0.1	1

Нийт хулгайн хэрэг 349 байгаагаас 93.4 хувь нь иргэний өмчийн хулгай, 4.9 хувь нь халаасны хулгай, 0.9 хувь нь авто тээврийн хэрэгслийн хулгайн хэрэг байна.

Зураг 21. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хороогоор



Хүснэгт 18. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хороогоор

Хороо	Гэмт хэрэг		Өөрчлөлт		Хүнийг алах	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	Хүчин	Хулгай	Үүнээс			Дээрэмдэх	Залилан мэхлэх	Малын хулгай	Олон нийтийн амгалан тайван байдал аллагчлах	ХАБТХАЖЭ	Бусад
	2016.VIII сар	2017.VIII сар	Тоо	%							ИӨХ	Авто тээврийн хэрэгсэл хулгайлах	Халаасны хулгай						
1	64	51	-13	-20.3			14		1	9	7		2	5	11		2	4	5
2	135	118	-17	-12.6		1	29			35	33	2		2	16		6	9	20
3	144	124	-20	-13.9		3	37		1	30	28	1	1		7		7	14	25
4	87	99	12	-13.8	1	4	23			45	37		7	1	5	1	2	5	12
5	26	21	-5	-19.2		1	5		1	8	7		1						6
6	16	30	14	87.5			12		1	8	8						2	2	5
7	23	21	-2	-8.7		2	3			9	9				1		2	1	3
8	46	51	5	10.9	1	2	20	1		20	19					1	2	1	4
9	46	39	-7	-15.2		3	11	1	1	10	10			1	1		4	3	5
10	93	112	19	20.4		4	34			27	26			1	8		6	12	20
11	121	122	1	0.8		3	39	2		41	38		3		20			3	16
12	32	43	11	34.4		2	12			18	18				1	2	2	2	4
13	17	30	13	76.5		2	8		3	9	9			1		2		4	1
14	35	33	-2	-5.7		1	5		2	14	14			12	2		1	3	3
15	165	160	-5	-3.0	2	1	45			43	41	2	2	3	20		9	9	28
16	58	55	-3	-5.2			18			23	22		1	1	3		2	2	6
ДҮН	1108	1109	1	0.1	4	29	315	4	10	349	326	3	17	17	95	6	47	74	163

ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ

2017 оны эхний 8 сарын байдлаар Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газарт иргэдээс 2299 өргөдөл, гомдол ирсний 1347-ыг нь хуулийн дагуу хугацаанд нь хариу өгч ажиллажээ. Шийдвэрлэх хугацаа болоогүй 943 өргөдөл байна.

Хүснэгт 19. Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ

Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын тоо	Хэлбэр				Агуулга				Бусад байгууллагад шилжүүлсэн	Хуулийн хугацаанд хариу өгсөн	Хүлээгдэж байгаа	Хугацаа болоогүй	Хугацаа хэтэрсэн
		Амаар	Бичгээр	Утсаар	Цахим сүлжээгээр	Гомдол	Санал	Мэдэгдэл	Хүсэлт					
ТЗУХ	272	249			23	11		261		266		6		
СТСХ	1				1	1				1				
ТГХШХ	7	7						7		7				
НХХ	31	27			4	3		28		26		5		
ТНААХ	136	73			63	54	1	81		125		11		
ХХҮХ	48	39			9	8	1	39		42		6		
Цэргийн штаб	56	56			0			56		56				
Хууль зүйн тасаг	31	29			2	7	1	23		30		1		
ЗДТГ-ын дүн	582	-	480	-	102	84	2	1	495	-	553	-	29	-
ХХ														
ХХҮХ	154	151			3	2		152		154		913		
Газрын алба	1049	927			122			1049		136		1		
БоХ	113	47		6	60	48	12	6	47	9	103			
ОБХ														
Албан бус- НТБ төв	365	365						365		365				
БХ	36	36						36		36				
Дэргэдэх хэлтэс албадын дүн	1717	365	1161	6	185	50	12	6	1649	-	794	-	914	-
ДҮН	2299	365	1641	6	287	134	14	7	2144	9	1347	-	943	-

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС
Танилцуулгыг эрхлэн гаргасан: мэргэжилтэн Г.Энхцэцэг

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?



СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН
1212.mn

 Цахимаар:

www.1212.mn

Статистик мэдээллийн
нэгдсэн сан



www.nso.mn

Та статистик мэдээллийг байнга
авч байхыг хүсвэл ЭНД ДАРЖ
бүртгүүлнэ үү

Энэ хэсэгт өөрийн e-mail
хаягаа бүртгүүлснээр
статистикийн мэдээллийг
цаг алдалгүй тогтмол авч
байх болно.

SOCIAL NETWORK



[www.facebook.com/
Статистик-Мэдээлэл](http://www.facebook.com/Статистик-Мэдээлэл)



[www.twitter.com/
statistic_mn](http://www.twitter.com/statistic_mn)



Ухаалаг гар утас, таблет
ашиглан статистик мэдээлэл
авах ezStat аппликейшн



Статистикийн хэвлэмэл
бүтээгдэхүүнийг унших
МОНСТАТ аппликейшн



Download on the
App Store

Google play



Утсаар:



Лавлах утас

1900-1212

QR код уншуулж татаж авна уу.

